



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬАА  
ДУНДГОВЬ АЙМГИЙН  
АУДИТЫН ГАЗАР

48090 Дундговь аймаг,  
Сайнцагаан сум, Нарлаг баг  
Утас: 70-59-24-39, 70-59-22-08, 70-59-32-08  
E-mail: dundgovia@audit.gov.mn

ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ТӨСВИЙН  
ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ  
БЛХАГВАМАНДАЛ ТАНАА

2016.03.29 № 137  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Аудитын гэрчилгээ

Эрдэнэдалай сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон, аккруэл суурнар бэлтгэгдсэн, жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1-д заасан Төрийн аудитын орон нутаг дах салбар байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Үндэсний аудитын газрын харьяа Дундговь аймгийн Аудитын газраас аудит хийв.

Төсвийн захирагч нь тайлант хугацааны санхүүгийн тайланг холбогдох хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг, хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллага нь Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2015 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, санал дүгнэлт өгөх үүрэг, хариуцлага хүлээнэ.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Дундговь аймгийн Аудитын газар нь аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2015 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлтийг болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Эрдэнэдалай сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ОЮУНЧИМЭГ



**ДУАГ**

ДУНГОВЬ АУДИТЫН АУДИТЫН САЛАР

**ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ТӨСВИЙН  
ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН 2015 ОНЫ  
САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН**

**Аудитын тайлан**

**Нэмэлт мэдээлэл авахыг  
хүсвэл дараах хаягаар  
харилцана уу:**

Тэргүүлэх аудитор  
Т.ОЮУНЧИМЭГ  
Утас: 70592439  
Цахим хаяг:

Аудитын менежер:  
Б.ГАНТУЯА  
Утас: 70592225  
Цахим хаяг:

Аудитор:  
Т.Оюун-Эрдэнэ  
Утас: 70593113  
Цахим хаяг:

ТАБ-ын хаяг: Дундговь

2016 оны 3 дугаар сар

ДУА-2016/13/САГ-ТТЗ

**Хавсралт 1:** Аудитын гэрчилгээ  
**Хавсралт 2:** Менежментийн захидал  
**Хавсралт 3:** Аудит хийгдсэн санхүүгийн  
тайлан  
**Хавсралт 4:** Аудит хийгдсэн төсвийн  
гүйцэтгэлийн тайлан

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйцээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Зөвлөмж
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

## **2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин:**

Эрдэнэдалай сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь Монгол улсын Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн албаны тухай хууль, Авилгын эсрэг хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Татварын ерөнхий хууль болон түүнтэй холбогдох хууль, Монгол Улсын Засаг захиргааны нэгж түүний удирдлагын тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль эрх зүйн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант онд санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хуулинд өөрчлөлт ороогүй боловч зарим хууль, хуулийн заалтад өөрчлөлт орсон байна. Тухайлбал: Эрүүл мэндийн даатгалын тухай, Нийгмийн даатгалын тухай хуулиудын зарим заалтад өөрчлөлт орсон байна.

## **2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:**

**Зорилго:** Иргэдийн хууль ёсны ашиг сонирхлыг эрхэмлэж, төрийн үйлчилгээг хүртээмжтэй, тэгш шудрага үр нөлөөтэй хүргэх, Төрийн үйлчилгээний шуурхай байдал чанар хүртээмжийг сайжруулж, өрхийн амьжиргааны чадавхийг дээшлүүлэх, хүний хөгжлийг бүх талаар хангах замаар орон нутгийн тогтвортой хөгжлийг хангана.

**Чиг үүрэг:** Орон нутагтаа боловсрол, эрүүл мэнд, спорт, төрийн нийтлэг үйлчилгээг хүргэх, иргэдийн ая тухтай амьдрах орчин нөхцлийг бий болгоно гэж заасан байна.

Дээрх зорилгыг хэрэгжүүлэхийн тулд Төсвийн тухай хуулийн 15.1. *“Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн удирдлага дор төсвийн шууд захирагчийг харьяалах эрх бүхий төсвийн төвлөрүүлэн захирагчтай байж болно”* гэж заасны дагуу Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын Засаг дарга Б.Лхагвамандал төсвийн төвлөрүүлэн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна

Эрдэнэдалай сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

## **4. Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:**

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулиудыг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Эрдэнэдалай сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа./ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорилыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Эрдэнэдалай сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн болон харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Эрдэнэдалай сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн болон харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн "Acoulous" програмаар боловсруулж, санхүүгийн нэгтгэсэн тайланг "Plastic" програмаар нэгтгэн тайлан бэлтгэх аргачлалын дагуу гаргасан байна.

#### **5. Дотоод хяналт:**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Эрдэнэдалай сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн дотоод хяналт эрсдлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

#### **6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар**

Батлагдсан төсвийг хуваарийн дагуу аймгийн Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан байна.

Эрдэнэдалай сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2015 оны үйл ажиллагааг санхүүжүүлэх эх үүсвэр 2,228,041.8 мянган төгрөгөөр батлагдсанаас тусгай шилжүүлгээр 1,548,691.8 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 645,386.2 мянган төгрөг, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 7,647.1 мянган төгрөг, өмнөх оны үлдэгдлээс 20,715.6 мянган төгрөг, нийт 2,222,440.7 мянган төгрөгийн эх үүсвэрээр үйл ажиллагаа явуулсан байна.

Тайланг онд үлдэгдэл 4,370.0 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлж, батлагдсан төлөвлөгөөнөөс 5,601.1 мянган төгрөгөөр дутуу санхүүжсэн байна.

#### **• Орон нутгийн орлогын талаар:**

Санхүүгийн нэгтгэсэн тайлан дах орон нутгийн орлогын гүйцэтгэлийг аймгийн Татварын хэлтсийн 2015 оны жилийн эцсийн мэдээтэй тулган шалгахад 135.7 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. Энэ нь Татварын хэлтсийн орлогын мэдээ дутуугаас шатгаалсан байна.

Орон нутгийн орлогыг 42,472.0 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 47,538.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн нь төлөвлөгөөтэй харьцуулахад 5,066.0 мянган төгрөгөөр буюу 11.9 хувиар давуулж, орлогыг нэр төрөл тус бүрээр биелүүлсэн байна.

Орон нутгийн орлогын төлөвлөгөө гүйцэтгэлийг нэр төрлөөр авч үзвэл:

/мян.төг/

ДУА-2016/13/САГ-ТТЗ

хуудас 5

ОРЛОГЫН ТӨРӨЛ	Татварын мэдээ			Нэгтгэсэн	Зөрүү
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү		
<b>Татварын орлого</b>	<b>33822.0</b>	<b>38167.8</b>	<b>4345.8</b>	<b>38167.8</b>	<b>0.0</b>
ИОГТХ	22500.0	26839.2	4339.2	30745.2	3906.0
Жишгээр ногдуулсан татвар	2100.0	2100.0	0.0		-
Патент	1800.0	1806.0	6.0		1806.0
Бууны албан татвар	122.0	122.0	0.0	122.0	0.0
Улсын тэмдэгтийн хураамж	3250.0	3250.1	0.1	3250.1	0.0
Хог хаягдлын үйлчилгээ	1050.0	1050.5	0.5	1050.5	0.0
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	3000.0	3000.0	0.0	3000.0	0.0
<b>Татварын бус</b>	<b>8650.0</b>	<b>9234.5</b>	<b>584.5</b>	<b>9370.2</b>	<b>135.7</b>
Хүү торгууль	6000.0	6000.0	0.0	6000.0	0.0
Төсвийн өөрийн орлого	1150.0	1734.5	584.5	1870.2	135.7
Бусад	1500.0	1500.0	0.0	1500.0	0.0
<b>Сумын нийт дүн</b>	<b>42472.0</b>	<b>47402.3</b>	<b>4930.3</b>	<b>47538.0</b>	<b>135.7</b>

• Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогын талаар:

Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогыг нийт 6,910.4 мянган төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 7,670.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, төлөвлөгөөг 760.2 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Үйл ажиллагааны орлогыг төсөвт байгууллагаар харуулбал:

/мян.төг/

№	Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелүүлсэн /гасарсан/
1	Засаг даргын Тамгын газар	1,150.0	1,870.2	720.2
2	Спорт хороо	2,050.0	2,086.4	36.4
3	Сургууль	1,210.4	1,213.0	2.6
4	Соёлын төв	2,500.0	2,501.0	1.0
	<b>Дүн</b>	<b>6,910.4</b>	<b>7,670.6</b>	<b>760.2</b>

7. Шилэн дансны мэдээлэл:

Эрдэнэдалай сумын төвлөрүүлэн захирагч болон түүний харьяа байгууллагууд нь шилэн дансны нэгдсэн сайтад бүтэн жилээр нэг удаа оруулах 8 мэдээлэл, 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, дараа жилийн төсвийн төслийг PDF файлаар шилэн дансны [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) сайтад оруулсан байна.

#### **8.Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:**

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын уламжлалт болон хяналтын эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр хяналтын 3, нарийвчилсан 5 нийт 8 горим, сорил гүйцэтгэлээ.

Төсвийн шууд захирагч нарын санхүүгийн тайлангийн аудитаар хэрэгжүүлсэн горим нарийвчилсан сорилоор нэгтгэсэн тайланд хамрагдах зарим байгууллага нь /Засаг даргын тамгын газар, Цэцэрлэг, Спорт хороо/ төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан, батлагдаагүй орон тоон дээр ажил хавсарсны нэмэгдэл олгосон, түлш халаалтын зардлаас галч нарын цалин олгосон, төрийн сангийн тэмдэг, дугааргүй үнэт цаас тасалдаг, гадны машинд шатахуун олгохдоо гэрээ байгуулж холбогдох тооцоог хийгээгүй, өглөг дутуу тайлагнасан, орлого зардлыг дутуу тайлагнасан зэрэг зөрчил илэрсэн. Энэ нь санхүүгийн тайлангийн оршин байх, эрх ба үүрэг, иж бүрэн байх, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангаагүй бөгөөд дараах сөрөг үр дагаварт хүрэх эрсдэлтэй байна. Үүнд:

- Дотоод хяналт сулрах, ажлын хариуцлага алдагдах,
- Холбогдох хуулийн заалт хэрэгжихгүй байх,
- Төсвийн хэмнэлтийн горим хэрэгжүүлэхгүй, төсвийг үр ашиггүй зарцуулах,
- Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

#### **9. Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар:**

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, бараа материал, цалин хөлс, түлш халаалт, томилолт, орлого зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцоолуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгав. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр хэрэгжүүлсэн горим, нарийвчилсан сорилоор нийт хөрөнгийн 68 хувь, нийт зардлын 72 хувийг тус тус аудитад хамрууллаа.

#### **10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:**

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв.

Нэгтгэсэн санхүүгийн тайланд нийт 6 байгууллага, 5 сангийн тайлан, орон нутгийн ерөнхий орлогын тайлан хамрагдсаны 3 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт өгөв. Үүнээс 2 байгууллага зөрчилгүй, 1 байгууллагад хязгаарлалтай дүгнэлт өгсөн.

Аудитын явцад материаллаг хэмжээний 6,684.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсэн байна. Үүнд:

1. Засаг даргын нөөц хөрөнгөөр наадам тэмдэглэхдээ 200.0 мянган төгрөгийн архи худалдан авсан.

ДУА-2016/13/САГ-ТГЗ

хуудас 7

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д /батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах/, Засгийн газрын 2002 оны “Төсвийн үр ашиггүй зардлыг бууруулах зарим арга хэмжээний тухай” 200 дугаар тогтоолын 4-д /Засгийн газрын гишүүн, Ерөнхийлөгчийн тамгын газар, Улсын их хурлын тамгын газар, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын удирдлага, аймаг нийслэлийн засаг дарга, иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн дарга, дэд сайд, яамдын төрийн нарийн бичгийн дарга, засгийн газрын агентлагийн дарга, төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуй нэгжийн гүйцэтгэх захирал, тэдгээртэй адилгах албан тушаалтануудаас ёслол, хүндэтгэлийн арга хэмжээ зохион байгуулахдаа засгийн газрын 1994 оны 76 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хүндэтгэлийн зоог барих болон ёслол хүндэтгэлийн бусад арга хэмжээг зохион байгуулахад согтууруулах ундаа хэрэглэх журам”-д заагдсан хэмжээг баримтлах, бусад тохиолдолд согтууруулах ундаа хэрэглэхийг хориглосугай/ гэж заасныг тус тус зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төлбөрийн акт тогтоож төлбөрийг төрийн сангийн 080000955 тоот дансанд 3 дугаар сарын 18-ны өдөр төвлөрүүлсэн байна.

2. Батлагддаггүй орон тоонд ажил хавсарсны нэмэгдэл цалин 1,222.4 мянган төгрөгийг олгосон /ЗДТГ/

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-д /Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох/, мөн хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д д /Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах/ гэж заасныг,

Төрийн сангийн тэмдэг, дугааргүй 1,458.9 мянган төгрөгийн үнэт цаас тасалсан /Спорт хороо/

Энэ нь Дундговь аймгийн Засаг даргын 2009 оны 97 дугаар захирамжаар батлагдсан “Үнэт цаас, тасалбарын маягт хэвлүүлэх, бүртгэх, зарцуулах” журмын 1.3-д /Хэвлэлтээс гарсан үнэт цаас, тасалбарын маягтыг Санхүү төрийн сангийг орлого хариуцсан мэргэжилтэн /Суманд төрийн сангийн төлөөлөгч/-д бүртгүүлэн, улиралд шаардагдах үнэт цаас, тасалбарын маяганд төрийн сангийн тэмдэг даруулж, акт үйлдэн баталгаажуулж авна/ гэж заасныг тус тус зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Зөрчлийг арилгах, давтан гаргахгүй ажиллах албан шаардлагыг хүргүүлсэн.

3. Түлш халаалтын зардлаас 3,180.2 мянган төгрөгийг галч нарын цалинд олгосон, хувь хүний тээврийн хэрэгслээр ажил үйлчилгээ гүйцэтгүүлэхдээ гэрээ байгуулаагүй 622.6 мянган төгрөгийн шатахуун олгосон /Спорт хороо/

**Шийдвэрлэсэн нь:** Зөрчлийг цаашид давтан гаргахгүй ажиллах зөвлөмжийг менежментийн захидлаар байгууллагын удирдлагад хүргүүлээ.

Аудитын явцад материаллаг бус 387,848.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсэн байна. Үүнд:

1. Өглөгийг 23.4 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан /Цэцэрлэг/, 4 дүгээр улирлын элэгдлийг бодуулаагүй 1,152.9 мянган төгрөгөөр элэгдлийн зардлыг дутуу тайлагнасан



/спорт хороо/, Орлого, зардлыг 386,672.6 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан /ЗДТГ-707,1 мянган төгрөг, цэцэрлэг- 25,472.0 мянган төгрөг, Нэгтгэсэн тайлан – 360,493.5 мянган төгрөг/

**Шийдвэрлэсэн нь:** Алдаа зөрчлийг санхүүгийн тайланд залруулга хийлгэж ажилласан.

#### **11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:**

Эрдэнэдалай сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2015 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг бус залруулагдаагүй алдаа, зөрчил байхгүй.

#### **12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал:**

Тайланта хугацаанд анхаарал татахуйц чухал асуудал гараагүй болно.

#### **13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:**

Тухайн аудитын хамрах хүрээний асуудал боловч цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан аудитын явцад гүйцээж шалгаж амжаагүй эрсдэлтэй байж болох Төсвийн шууд захирагчдын эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалтыг завсрын аудитаар шалгах нь зүйтэй гэж үзлээ.

#### **14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:**

Эрдэнэдалай сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 394,533.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба үүнээс 200.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 3,802.8 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч, 2,681.3 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, хүргүүлэв. Материаллаг бус 387,848.9 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэж ажилласан.

#### **15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:**

Эрдэнэдалай сумын 2014 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аймгийн Аудитын газраас зөрчилгүй дүгнэлт өгч зөвлөмж өгөгдөөгүй байна.

#### **16. Зөвлөмж:**

Аудит хийх явцад зөвлөмжийг холбогдох албан тушаалтануудад өглөө.

#### **17. Зөрчилгүй санал дүгнэлт:**

Эрдэнэдалай сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудит хийгдсэн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, хавсралт, тодруулгуудыг хавсаргав.

**АУДИТЫН ТАЙЛАНГ**

ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Т.ОЮУНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР  Б.ГАНТУЯА

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР  Т.ОЮУН-ЭРДЭНЭ

2016.03.25